



**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.07.10.

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Зам, тээврийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

Зам, тээврийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, ТНБД-ын тушаалын биелэлт, ТНБД-ын зөвлөлийн хуралдааны төлөвлөгөөний биелэлт, ТНБД-ын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **81.7%**-тай байна.

/Хүснэгт 1/

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Хэрэгжилт хувь
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	49	35	84.3
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	4	3	100.0
3	Сайдын тушаалын биелэлт	91	87	65.9
4	ТНБД-ын тушаалын биелэлт	53	51	92.0
5	Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдааны төлөвлөгөөний биелэлт	13	11	100.0
6	Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт	22	22	100.0
7	Нийтийн мэдээллийн ил тод байдлын биелэлт	2	2	30.0
Нийт		234	211	81.7

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. ХШУДАГ-ын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

/Хүснэгт 2/

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлт /хувиар/
	100%	90%	70%	50%	30%	0%		
49	18	10	1	-	6	0	14	84.3

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 2025 онд 49 арга хэмжээ хэрэгжүүлэхээр Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлан ажилласан байна. Эхний хагас жилийн байдлаар нийт 49 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 18 арга хэмжээ, 90%-ийн биелэлттэй 10 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 1 арга хэмжээ, 30%-ийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ, хэрэгжилт дунджаар 84,3%-тай байна.

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр тус газарт 4 үүрэг даалгавар өгөгдсөнөөс бүрэн хэрэгжсэн 3, хугацаа болоогүй 1 арга хэмжээний дундаж үнэлгээ **100.0 хувь** байна.

/Хүснэгт 3/

Нийт заалт	Үүнээс				Биелэлт /хувиар/
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
4	3	-	1	-	100.0

2.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

/Хүснэгт 4/

Нийт заалт	Үүнээс				Биелэлт /хувиар/
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
91	58	30	4	-	65.9

Сайдын тушаалаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт өгөгдсөн 91 үүрэг даалгавраас “тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах тухай” 87 үүрэг даалгавар байна. Харин тус газарт хамаарах 4 үүрэг даалгавраас бүрэн хэрэгжсэн 2, хугацаанд хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй 2 заалт байна.

2.4. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт өгөгдсөн 53 үүрэг даалгавраас “тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах тухай” 51 үүрэг даалгавар байна. Харин тус газарт хамаарах 2 үүрэг, даалгавар бүрэн хэрэгжсэн байна.

/Хүснэгт 5/

Нийт заалт	Үүнээс				Биелэлт /хувиар/
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
53	36	17	2	-	92.0

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгавраас хэрэгжээгүй 17 арга хэмжээ байгаа ба эдгээр үүрэг даалгаврууд нь бусад нэгж, харьяа байгууллагад үүрэг даалгавар өгч, тус газраас тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах заалтууд байна.

2.5. Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдааны төлөвлөгөөний биелэлт:

Тус газар нь Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдаанаар 2025 онд 16 асуудал хэлэлцүүлэхээр төлөвлөж, эхний хагас жилийн байдлаар 13 асуудал хэлэлцүүлэхээс хугацаандаа хэлэлцүүлсэн буюу хэрэгжсэн 11, зөвлөлөөр хэлэлцүүлэх шаардлагагүй болсон 2 асуудлын дундаж үнэлгээ **100.0 хувь** байна.

/Хүснэгт 6/

№	Хугацаа /улирлаар/	Нийт арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/						Биелэлт /хувиар/
			100	70	30	0	Хэлэлцүүлэх шаардлагагүй	Хугацаа хойшлуулсан	
Нийт		13	11	-	-	-	2	-	100.0

2.6. Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт:

Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдааны 11 шийдвэрээс өгөгдсөн 22 үүрэг даалгаврын хэрэгжилт 100 хувьтай.

/Хүснэгт 8/

Хугацаа /оноор/	Шийдвэрийн Тоо, хэмжээ	Шийдвэрээр өгсөн үүрэг	Үнэлгээ				Хугацаа болоогүй	Биелэлт /хувиар/
			100	70	30	0		
2025	11	22	22	-	-	-	-	100.0

2.7. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

/Хүснэгт 9/

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс /хувиар/					Биелэлт /хувиар/
		100	70	30	0	хамааралгүй	
Нийт	2	-	-	2	-	-	30.0

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

3.1. Төлөвлөлтийн байдал:

3.1.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын үйл ажиллагааны онцлог нь тогтмол байнгын давтагдах шинжтэй байдаг. 2025 онд тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 49 арга хэмжээг төлөвлөсөн байна. Үүнээс хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр 18 арга хэмжээ, санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр 16, дотоод аудитын чиглэлээр 13, хяналт-шинжилгээ, үнэлгээний журам шинэчлэн боловсруулах, хяналт-шинжилгээ, үнэлгээний программыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэлээр 2 арга хэмжээг төлөвлөгөөнд тусгасан байна.

3.1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахад санхүүгийн болон дотоод аудит хийх арга хэмжээний зорилтод түвшинг нийтлэг байдлаар I-IV улирлаар тодорхойлсон мөн шалгуур үзүүлэлт зорилтод түвшин уялдуулаагүй алдаа гарсан байна.

3.2. Хэрэгжилтийн байдал:

3.2.1. Зам, тээврийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, ТНБД-ын тушаалын биелэлт, ТНБД-ын зөвлөлийн хуралдааны төлөвлөгөөний биелэлт, ТНБД-ын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээ гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **81.7 хувьтай** байна.

3.2.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг дүгнэхэд Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн хэрэгжилттэй байна. Энэ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан тогтмол мэдээлэх ёстой санхүү, дотоод аудитын хяналт, шалгалтын мэдээлэл болон ХШҮ-ний тайланг яамны сайтад байршуулаагүй байна. Мөн Сайдын тушаалаар тус газарт өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт 65.9 хувиар үнэлэгдсэн байна.

3.2.3. 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 49 арга хэмжээний хэрэгжилт 84.3 хувь байна. Үүнээс 82,8 % нь хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 17.2 % нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна.

3.2.4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

/Хүснэгт 10/

Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилт хувь
Зорилт 1: Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргаж, гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;	7	98.0
Зорилт 2: Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргаж, гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;	6	81.6
Зорилт 3: Яам, агентлаг, харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, зөвлөмж гаргаж, гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;	7	90.0
Зорилт 4: Санхүү, төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргаж, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;	16	98.8
Зорилт 5: Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, яам болон салбарын харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргаж, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;	13	60.0

3.2.5. Тус газрын 2025 гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан дотоод аудитын төлөвлөгөөт хяналт шалгалт хийх арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хийхэд анхаарч

ажиллах шаардлагатай байна. Энэ нь тус газрын ажлын байрны ачаалал, ажил үүргийн тэнцвэртэй байдлыг хангагдаагүй буюу дотоод аудитын төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийхэд албан хаагчдын хүн хүч хүрэлцээгүй улмаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй, хойшлогдсон байна.

3.2.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 1 дүгээр улирлын байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

4.1. Газрын 2025 гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан дотоод аудитын төлөвлөгөөт хяналт шалгалт хийх ажлыг эрчимжүүлэх, төлөвлөсөн арга хэмжээг хугацаанд хийх, үр дүнг тооцож ажиллах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавих, хэрэгжилтийг үнэлэх, яамны болон харьяа байгууллагын хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний программын хэвийн ажиллагааг III улиралд багтаан нэвтрүүлэх;

4.2. Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор "Хяналт-шинжилгээ хийх журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Үнэлгээ хийх журам"-ыг 2 дугаар хавсралт, "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ыг 3 дугаар хавсралтаар тус тус батлагдсан тул Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар батлагдсан "Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг шинэчлэн батлуулж, 2025 оны 3 дугаар улирлын үйл ажиллагааг дүгнэх ажлыг зохион байгуулж ажиллах;

4.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хяналт-шинжилгээ, үнэлгээний хариуцсан ажлын байрны сул орон тоог яаралтай нөхөх, ажлын ачаалал болон ажил үүргийн тэнцвэртэй байдлыг хангах чиглэлээр анхаарч ажиллах;

4.4. Үйл ажиллагааны биелэлтийг тайлагнахдаа тухайн арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинд заасан тоо хэмжээ, чанарын үзүүлэлтийн дагуу хэрэгжилтийг тайлагнаж, ажиллахыг газрын нийт албан хаагчдад тус тус зөвлөж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**ЗТЯ-НЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН
/хүснэгтээр/**

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Хэрэгжилтийн хувь
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	49	35	84.3
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	4	3	100.0
3	Сайдын тушаалын биелэлт	91	87	65.9
4	ТНБД-ын тушаалын биелэлт	53	51	92.0
5	Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхасуудлын төлөвлөгөөний биелэлт	13	11	100.0
6	Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт	22	22	100.0
7	Нийтийн мэдээллийн ил тод байдлын биелэлт	2	2	30.0
Нийт		234	211	81.7



**ЗТЯ-НЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН
/графикаар/**

